



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/638

Булган сум

Эрүүл мэндийн газрын дүрэм,  
бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2014 оны А/415 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт, 2020 оны А/37, А/38 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц, орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (М.Батчимэг), захирамжийн хэрэгжилтийг ханган удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар (П.Оюунцэцэг) нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн газрын дүрэм, бүтэц орон тоо батлах тухай" 2021 оны А/349 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6333010705



## АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДҮРЭМ

### Нэг.Ерөнхий зүйл

1.1 Аймгийн Эрүүл мэндийн газар нь үйл ажиллагаандаа Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагааг зохицуулж буй хууль болон бусад холбогдох хуулиуд, “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага, Нутгийн өөрөө удирдах ёсны болон Нутгийн захиргааны байгууллагын гаргасан шийдвэр, бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг удирдлага болгон ажиллана.

1.2 Эрүүл мэндийн газар нь иргэдээ дээдэлсэн, тэгш хүртээмжтэй, чанартай эрүүл мэндийн анхан шатны болон нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил, ур чадвараа дээшлүүлэх боломжоор хангах, үйл ажиллагаа нь иргэдэд нээлттэй ил тод, иргэдийн оролцоог хангасан байх зарчмыг баримтална.

### Хоёр. Эрүүл мэндийн газрын үнэт зүйл

2.1 Мэргэшсэн, ёс зүйтэй, мэргэжлийн өндөр ур чадвартай, хөрвөх чадвар бүхий хүний нөөц

2.2 Удирдлагын манлайлал, хариуцлага, ил тод байдал, алсын хараа, эрхэм зорилго, зорилт

2.3 Байгууллагын соёл, шинэ технологи, материаллаг нөөц, дэд бүтэц

2.4 Төрийн үйлчилгээний ээлтэй орчин, сэтгэл ханамжтай үйлчилгээ

### Гурав. Эрүүл мэндийн газрын эрхэмлэх зарчим

3.1 Төрийн хууль тогтоомж, стандарт, дүрмийг чандлан сахих

3.2 Хүнлэг, энэрэнгүй сэтгэл

3.3 Шудрага ёс ил тод байдал, хариуцлага

3.4 Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар

3.5 Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага

3.6 Үнэнч, шуурхай, чирэгдэлгүй төрийн үйлчилгээ

### Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1 Эрүүл мэндийн газар нь удирдлага, санхүү, аж ахуйн хувьд бие даан ажиллах ба “Эрүүл мэндийн газар” гэсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэх

4.2 Эрүүл мэндийн газрын “Удирдлагын зөвлөл”-ийг байгуулж, зөвлөлийн журмыг баримтлан ажиллах

4.3 Нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэнд, эмнэлгийн тусламж үйлчилгээ, хүний нөөцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгох, санхүү, хөрөнгө нөөцийг хуваарилах, хяналт тавих асуудлыг аймгийн хэмжээнд хариуцан, аймгийн Засаг дарга, Эрүүл мэндийн сайдад тайлагнах

4.4 Аймгийн Эрүүл мэндийн газрын бүтэц, орон тооны дээд хязгаарыг орон нутгийн онцлогт тохируулан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан “Аймгийн Эрүүл

мэндийн газрын үлгэрчилсэн дүрэм, үйл ажиллагааны чиглэл"-ийн жишгээр эрүүл мэндийн болон бусад холбогдох хууль, дүрэм, журмыг баримтлан аймгийн Засаг даргын шийдвэрээр баталгаажуулан ажиллах.

4.5 Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/38 дугаар тушаалыг баримтлан өөрийн бүтцэд "Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс"-ийг байгуулан ажиллаж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлагаар ханган ажиллаж, хяналт тавих

4.6 Аймгийн Засаг даргын шийдвэрийг үндэслэн Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдыг томилох

4.7 Эрүүл мэндийн газрын Удирдлага төлөвлөлт, санхүүгийн хэлтэс, Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс, Хяналт шалгалтын хэлтсийн мэргэжилтэн, албан хаагчид нь Эрүүл мэндийн газрын даргын шууд удирдлаганд ажиллах

### **Тав. Эрүүл мэндийн газрын эрх**

Эрүүл мэндийн газар нь "Эрүүл мэндийн тухай" хуулийн 12 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараах эрхийг эдэлнэ:

5.1 Эрүүл мэндийн салбарын харилцааг зохицуулж буй хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэн, Засгийн газар, Нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллага, аймгийн Засаг даргаас батлан гаргасан шийдвэрийн биелэлтийг салбарын хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцох

5.2 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагуудад хяналт үнэлгээ хийх, мэргэжил арга зүй, удирдлагаар ханган, дотоодын хяналт тавих, үүрэг даалгавар өгч, биелэлтийг шаардах, хариуцлага тооцон ажиллах

5.3 Хүн амын эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулж, эрүүл мэндийн үйл ажиллагаанд орон нутгийн засаг захиргааны байгууллага, олон нийтийн оролцоог хангах

5.4 Үйлчлүүлэгч төвтэй чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг нэвтрүүлэх талаар онцгойлон анхаарч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, тусламж үйлчилгээтэй холбогдон гарсан иргэдийн санал, хүсэлт, гомдлыг барагдуулах, шийдвэрлэх

5.5 Байгууллагын батлагдсан орон тоонд мэргэжилтнүүдийн чиг үүргийг тодорхойлж, Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагаажуулан ажиллах

5.6 Хэлтсийн даргын албан үүргийг үндсэн орон тооны мэргэжилтэнээр давхар гүйцэтгүүлэх

5.7 Өөрийн харъяа Эрүүл мэндийн байгууллагуудын үлгэрчилсэн бүтэц, дүрмийг батлах

5.8 Эмнэлгийн мэргэжилтнүүдийн орон нутагт нэвтрүүлсэн, дэвшилтэт технологи, шинэ бүтээлд дүгнэлт гаргах, санал өгөх, урамшуулах

5.9 Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа төрийн албан хаагчдыг шагнаж урамшуулах, төрийн одон, Засгийн газар, Эрүүл мэндийн яам болон аймгийн шагналд тодорхойлох

5.10 Өөрийн орны болон гадаад орны Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хэрэгжилтийг зохион байгуулан, үр дүнг тооцон ажиллах

5.11 Орон нутгийн хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган хэрэгжилтийг тооцон үйл ажиллагаанд хяналт тавьж, тайлагнах

5.12 Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлогыг тодорхойлон, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар удирдлага зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээ авч ажиллах

5.13 Аймгийн Засаг даргатай зөвшилцөн, аймгийн Нэгдсэн эмнэлгийн даргыг хууль тогтоомжид зааснаар томилж, чөлөөлөх.

5.14 Сумын Эрүүл мэндийн байгууллагуудын дарга нарыг томилж, чөлөөлөхөд хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд холбогдох байгууллагад санал хүргүүлэх, томилох, чөлөөлөх

5.15 Хуульд заасан эрхийн хүрээнд ажилтныг томилох, чөлөөлөх, албан тушаалаас нь бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, түр чөлөөлөх, халах

### **Зургаа. Эрүүл мэндийн газрын үүрэг:**

6.1 Эрүүл мэндийн салбарын харилцааг зохицуулж буй хууль тогтоомжууд, арга хэмжээний төлөвлөгөө, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, Нутгийн өөрөө удирдах ёсны болон Нутгийн захиргааны байгууллагуудаас гаргасан эрх зүйн актууд, норм, норматив, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах

6.2 Засгийн газрын болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулж, үр дүнг тооцож, тухай бүр нь тайлагнах

6.3 Сумын Засаг дарга, Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах гурвалсан гэрээг байгуулж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж, стандартын түвшинг нэмэгдүүлэн, хагас жил тутам шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж, үр дүнг тооцон, эргэн мэдээлэл, мэргэжлийн байгууллагын зөвлөмжөөр ханган ажиллах

6.4 Аймгийн Засаг даргаар ахлуулсан "Эрүүл мэндийн салбар зөвлөл"-ийн ажлын албаны үүргийг гүйцэтгэж, хурал зохион байгуулах, хэлэлцүүлэх асуудлыг нэгтгэн бэлтгэх

6.5 Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлж, орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн зорилт, стратеги, тэргүүлэх чиглэлийг тодорхойлон, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөр стратегийг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжүүлэх

6.6 Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд, орон нутгийн удирдлагыг мэргэжил, арга зүйгээр хангаж, хамтран ажиллах

6.7 Орон нутагт халдварт болон халдварт бус өвчний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран явуулах, өвчлөлийн хүчин зүйлийн эсрэг авах хариу арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулан, үр дүнг тооцон ажиллах

6.8 Хүн амын дунд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээ хийж, зонхилон тохиолдож буй өвчин эмгэгийг эрт илрүүлэн эмчлэх талаар удирдлага зохион байгуулалтын нэгдсэн арга хэмжээг авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулах

6.9 Орон нутгийн орчны бохирдол, эрсдэлт хүчин зүйлийг тооцох, хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг судлаж, эрүүл мэндийг дэмжигч орчин бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг сайжруулан хамтран ажиллах

6.10 Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран гүйцэтгэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох судалгаа хийж, тэргүүлэх чиглэл болон хэтийн төлвийг тодорхойлох

6.11 Эмнэлгийн орыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зохицуулалт хийх

6.12 Ядуу, эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийт, олон улсын байгууллагатай хамтран ажиллаж, тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг нэмэгүүлэх

6.13 Харьяа Эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээний талаарх иргэд, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тодорхой давтамжтайгаар авч мэдээлэх, судалгааны мөрөөр арга хэмжээ авч хэрэгжүүлэх

6.14 Албан бус төлбөрийг бууруулах, төлбөртэй тусламж үйлчилгээний үнэ тарифыг иргэдэд ил тод, нээлттэй байлгах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих

6.15 Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндэд нөлөөлж буй нөлөөллийн үнэлгээ болон эрүүл мэндийн байгууллагуудын эрсдлийн үнэлгээг холбогдох байгууллагатай хамтран хийж, үнэлгээнээс гарсан дүгнэлт зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох дээд шатны байгууллагад танилцуулж, шийдвэрлүүлэх

6.16 Орон нутагт эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хэрэгцээ шаардлагыг судлан, нотолгоонд суурилсан, иргэдэд чиглэсэн, хууль дээдэлсэн төрийн ухаалаг үйлчилгээ үзүүлэх

6.17 Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, сайжруулахад төрийн, болон төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулахад онцгой анхаарч ажиллах

6.18 Хүний эрх, жендерийн тэгш байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх

6.19 Эмнэлгийн барилга, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамж, засвар үйлчилгээг нэгтгэн зохион байгуулах асуудлыг зохицуулан, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангийн бүтэц, үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах, мэргэжлийн удирдлагаар хангах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх

6.20 Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хэрэгцээг тодорхойлж, тасралтгүй хангах төлөвлөлтийг хэрэгжүүлэх, эмнэлгийн мэргэжилтэнүүдийн мэргэжлийн мэдлэг, үр чадварыг сайжруулах, тасралтгүй хөгжүүлэх стратегийг хэрэгжүүлж, үр дүнг тооцон, мэргэжлийн зэрэгтэй төрийн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх

6.21 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, тогтмолжуулан, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагааг эрчимжүүлэн, ёс зүйн алдаа доголдлыг бүртгэж, холбогдох арга хэмжээг тухай бүр нь авч хэрэгжүүлэх

6.22 Байгууллага болон салбарын хэмжээнд дотоодын хяналт шалгалтыг холбогдох хууль, тогтоомжийг баримтлан удирдамж, төлөвлөгөөний дагуу зохион байгуулан үр дүнг тооцож, шаардлагатай арга хэмжээг тухай бүр нь шуурай авч ажиллах

6.23 Эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалтыг хийж, "Шилэн данс"-ны хуулийг хэрэгжүүлэн, салбарын хэмжээнд өр авлага үүсгэлгүй ажиллаж, төсвийн төлөвлөлт, зарцуулалтын талаархи мэдээллээр холбогдох байгууллагуудыг ханган ажиллах

6.24 Эрүүл мэндийн статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хүн амын эрүүл мэндийн талаар тулгамдаж буй асуудлыг тодорхойлоход шаардлагатай мэдээ мэдээллээр холбогдох байгууллагуудыг тухай бүр шуурхай хангах

6.25 Өөрийн харъяа төрийн болон хувийн хэвшлийн Эрүүл мэндийн байгууллагуудаас хүн амын өвчлөл, эндэгдлийн талаарх мэдээг цаг тухайд нь хүлээн авч нэгтгэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг эргэн мэдээллээр хангах

**Долоо. Эрүүл мэндийн газрын санхүүжилт**

7.1 Санхүүжилт нь улсын төсөв, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

7.2 Төсвийн зарцуулалтыг мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна.

7.3 Байгууллагын төрийн сангийн бие даасан данстай, бүртгэгдсэн эд хөрөнгөтэй байна.

7.4 Төрийн өмч, эд хөрөнгийг хууль, журмаар бүртгэн, эзэмшилтэнд дотоодын хяналт тавьж, тайлан тооцоог цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагуудад өгөх үүрэг хүлээнэ.

#### **Найм.Хамтын ажиллагаа**

8.1 Гадаадын улс орнуудын Эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, гадаадын мэргэжилтнээр ажил үйлчилгээ гүйцэтгүүлэх, гэрээ байгуулах, олон улсын байгууллагаас мэргэжилтэн, зочид, төлөөлөгч урих асуудлыг Эрүүл мэндийн Яам, аймгийн Засаг даргатай тохиролцон шийдвэрлэнэ.

8.2 Эрүүл мэндийн газрын даргын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох цаашид /албан томилолт/-ын асуудлаар тухай бүр аймгийн Засаг даргын шийдвэрээр шийдвэрлэнэ.

8.3 Байгууллагын төрийн албан хаагч нарын гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Эрүүл мэндийн газрын дарга шийдвэрлэнэ.

#### **Ес. Эрүүл мэндийн газрын үйл ажиллагаанд хориглох зүйл**

9.1. Улс төр, шашны зорилготой үйл ажиллагаа зохион байгуулах

9.2. Хууль тогтоомжинд зааснаас бусад хэлбэрээр орлого олох, үйл ажиллагаа явуулах

9.3. Ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй төрийн албан хаагчдыг ажиллуулах

9.4 Эрх мэдлээ урвуулан ашиглах

9.5 Төрийн өмчийг хувийн үйл ажиллагаанд ашиглах

9.6 Санхүүжилтыг зориулалт бусаар зарцуулах, шамшигдуулах

Аймгийн Засаг даргын 2023 оны дүгээр сарын 27 өдрийн захирамжийн хоёрдугаар хавсралт



ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

ДАРГА-1

УДИРДЛАГА ТӨЛӨВЛӨЛТ,  
САНХҮҮГИЙН ХЭЛТЭС-14

- Хэлтсийн дарга
- Ахлах мэргэжилтэн
- Хүний нөөцийн төлөвлөлт, хангалт, сургалт, мэргэжлийн зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн ажилтны нийгмийн асуудал, шагнал урамшуулал хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн эдийн засаг, төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн
- Хөрөнгийн бүртгэл, хөрөнгө сруулалтын төлөвлөлт, барилга байгууламж хариуцсан мэргэжилтэн
- Хууль эрх зүйн зөвлөгөө, ёс зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан мэргэжилтэн
- Салбарын санхүүгийн бүртгэл мэдээлэл хариуцсан мэргэжилтэн, байгууллагын нягтлан бодогч
- Нярав
- Үйлчлэгч
- Архив, бичиг хэргийн ажилтан
- Жолооч -1
- Жижүүр, ашиглалт хариуцсан ажилтан -4

НИЙГМИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ХЭЛТЭС-8

- Хэлтсийн дарга
- Ахлах мэргэжилтэн
- 1 Эрүүл мэндийн боловсрол мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
- Халдварт бус өвчний сэргийлэлт, хяналт хариуцсан мэргэжилтэн
- 2 Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- 3 Халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
- 4 Халдварт өвчний тандалт, сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
- Сэтгэцийн эрүүл мэнд, осол гэмтлийн тандалт хариуцсан мэргэжилтэн
- Өсвөр үе залуучууд ахмад настны эрүүл мэнд хариуцсан мэргэжилтэн
- 5 Дархлаажуулалт, аркутгал хариуцсан бага эмч

ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС-7

- Хэлтсийн дарга
- Ахлах мэргэжилтэн
- Эх барих, эмэгтэйчүүд, хүүхдийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, эрсдэл, цусан цусан бүтээгдэхүүний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн
- Эмнэлгийн магадлан итгэмжлэл, оношилгоо эмчилгээнээс шалтгаалх халдвар хариуцсан мэргэжилтэн
- Эмийн чанар, акулгүй байдал, эмийн зохистой хэрэглээ хариуцсан мэргэжилтэн
- Сувилгахуй, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Уламжлалт анагаах ухаан, сэргээн засах тусламж хариуцсан үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
- Сум, өрхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ, МЭДЭЭЛЛИЙН  
ХЭЛТЭС-4

- Хэлтсийн дарга
- Ахлах мэргэжилтэн
- Эрүүл мэндийн статистик мэдээлэл хариуцсан мэргэжилтэн
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн
- Мэдээллийн технологи, зайн анагаах ухаан хариуцсан мэргэжилтэн
- Эрүүл мэндийн мэдээний сан хариуцсан бага эмч

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТЭС-3

- Хэлтсийн дарга
- Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
- Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч
- Эмчилгээний чанарын хяналтын улсын ахлах байцаагч